БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

---

**Галуут сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

**Аудитын код: БНА-2020/100/СТА-ТШЗ**

---

Цахим хуудас:
Bayankhongor@audit.gov.mn

Баянхонгор хот

2020 он

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат

Утас: 70442584 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn

Аудитын менежер: А.Цээням

Утас: 70444470 Цахим хаяг:

Аудитор: Б.Бямбаа

Утас: 88050763 Цахим хаяг: Cpa_bymba@yahoo.com

---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| АОУС | Аудитын Олон Улсын Стандарт |

## Агуулга


Аудитын гэрчилгээ ..... 3

Аудитын тайлан ..... 5

2.1. Оршил ..... 5

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага ..... 5

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт ..... 5

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин ..... 5

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ ..... 6

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал ..... 6

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар ..... 6

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд ..... 6

2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга ..... 7

2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн ..... 7

2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал ..... 8

2.13. Шилэн дансны мэдээлэл ..... 8

2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт ..... 8

2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл ..... 8

Менежментийн захидал ..... **Error! Bookmark not defined.**

1.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан ..... 9

4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан ..... 10

4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан ..... 11

4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан ..... 13

4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан ..... 14

## Аудитын гэрчилгээ

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
64101 Баянхонгор аймаг,
Баянхонгор сум, Номгон баг
Утас, факс 7044 2584
E-mail; bayankhongor@audit.gov.mn

2020.02.20 № 1/145

танай ____________ -ны № ____________ -т

ГАЛУУТ СУМЫН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ
С.ЦЭГМИД ТАНАА

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-т заасны дагуу Галуут сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

**Зөрчилгүй санал дүгнэлт**

Галуут сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

**Санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Галуут сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл,санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийн хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

D:\бичиг хэрэг 2020-Албан тоот А4\
005020090

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

**Үүрэг хариуцлага**

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-т заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудитын хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Б.МӨНХБАТ

D:\бичиг хэрэг 2020-Албан тоот А4\

## 2.1. Оршил

Галуут сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг сургуулийн захирал С.Цэгмид танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

## 2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Галуут сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Галуут сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020.02.21-нээс 2020.02.23–ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020.02.27-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Баянхонгор аймаг дахь Хонгорын үр сад аудит ХХК-ны аудитор Б.Бямбаа хариуцаж хэрэгжүүлэв.

Галуут сумын Ерөнхий боловсролын сургууль 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Хонгорын үр сад аудит ХХК-ны газарт 2020.02.19-ны өдрийн 18 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

## 2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

## 2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Галуут сумын Ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагааны эрхэм зорилго нь " Суралцагчдын сурлагын ахиц амжилтыг дээдлэн,сурах арга барил,төлөвшил хандлагыг эрхэм болгож олон нийтийн оролцоог дэмжихэд оршино " гэсэн эрхэм зорилгыг дэвшүүлэн ажиллаж байна.

Галуут сумын Ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Үндэсний болон аймгийн дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэн ажиллах
- Чанартай,хүртээмжтэй, ахицтай боловсролын үйлчилгээг хүргэх
- Багш,сурагч солилцоо хөтөлбөр боловсруулан ажиллах
- Эцэг эх,олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх
- Хүүхдэд ээлтэй эрүүл орчин бүрдүүлэн ажиллах

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд: Өөрчлөлт ороогүй байна.

## 2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус Галуут сумын Ерөнхий боловсролын сургуулийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Галуут сумын Ерөнхий боловсролын сургууль нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд Санхүүгийн тооцоолох ХХК-ны Acolouc программ хангамж ашигладаг байна.

Галуут сумын Ерөнхий боловсролын сургуулийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд Дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

## 2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Галуут сумын Ерөнхий боловсролын сургуулийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 28 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэж баталгаажуулсан болно.

## 2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны 3 дугаар улирлын байдлаарх үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг "Их" гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2,0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 905594,0 мянган төгрөгөөс тооцон 18111,8 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 18111,8 мянган төгрөгөөр тооцсон нь төлөвлөлтийн шатанд сонгосон суурь үзүүлэлтийг өөрчлөөгүйтэй холбоотой болно.

## 2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Галуут сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 21743,4 мянган төгрөгөөр буюу 0,9%-иар хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 18532,8 мянган, бараа материалын дансны үлдэгдэл 14821,5 мянган төгрөгөөр өссөн материаллаг өөрчлөлт гарсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 0,00 | 0,00 | |

| | | | |
|---|---|---|---|
| Авлага | 575,6 | 441,2 | 134,4 |
| Урьдчилгаа | 0,00 | 0,00 | 0,00 |
| Бараа материал | 55916,6 | 70738,1 | 14821,5 |
| Үндсэн хөрөнгө | 1711858,3 | 1730391,1 | 18532,8 |
| Хуримтлагдсан элэгдэл | -173506,9 | -184983,4 | -11476,5 |
| **Нийт хөрөнгө** | 1594843,7 | 1616587,1 | 21743,4 |
| Өр төлбөр | 0,00 | 0,00 | 0,00 |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 1594843,7 | 1616587,1 | 21743,4 |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | 1594843,7 | 1616587,1 | 21743,4 |

Авлага өмнөх оноос 134,4 мянган төгрөгөөр буурсан ч 441,2 мянган төгрөгийн үлдэгдэлтэй гарсан ба энэ нь өмнөх оны үлдэгдэл барагдаагүй байгаа тул тодорхой арга хэмжээ авах шаардлагатай байна.

Үндсэн хөрөнгө тайлант онд 56240,8 мянган төгрөгөөр нэмэгдсэн ба энэ нь БСШУЯамнаас 28000,0 мянган төгрөгийн үнэ төлбөргүй тоног төхөөрөмж өгсөн, төсвийн хөрөнгөөр 27650,8 мянган төгрөгийн хөрөнгө авсныг орлогод бүрэн авсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл буурсан нь Галуут сумын ИТХТ-чдийн 2019.05.16-ны 14 тоот тогтоолоор 37708,0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг акталж данснаас хассанаас шалтгаалжээ.

Бараа материалын дансны үлдэгдэл 14821,4 мянган төгрөгөөр өссөн нь аж ахуйн болон засварын материалын үлдэгдэл нэмэгдсэнтэй холбоотой байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл өмнөх онд 464,5 мянган төгрөг байснаас тайлант хугацаанд барагдаж 150,0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй гарчээ.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэлд 22057,9 мянган төгрөгөөр тайлант хугацааны үр дүнгийн өөрчлөлтөөр нэмэгдсэн байна.

## 2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 12 хөтөлбөрт зориулан 871522,7 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 871522,7 мянган төгрөгийг урсгал зардалд зарцуулахаар батлагдсан байна.

Нийт зардлын 731629,6 мянган төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгээр, Орон нутгийн төсвөөс 139893,1 мянга санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 870113,5 мянган төгрөг буюу 99,8 хувьтай байгаа нь батлагдсан төсвийг 1409,1 мянган төгрөгөөр хэмнэж буцаан төвлөрүүлснээс шалтгаалсан байна.

**Нэмэлт төсөв**: Төрийн сангаас нэмэлт санхүүжилтээр БСУГ-аас боловсролыг дэмжих 26,0 сая төгрөг орж ирснийг Халзан хайрхан шүтээн ХХК-д шилжүүлэн сургалтын зардалд 5860,0 мянган төгрөг, 20140,0 материалын зардалд зарцуулсан байна.

## 2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 7 чиглэлээр 28 эрсдэлд нийт 28 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 28887,9 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрсэнд 2887,9 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоолоо.

Аудитын явцад санхүүгийн тайланд нэмэлт санхүүжилтийн орлогоор орсон 26000,0 сая төгрөгийн орлогын харилцах дансны хуулгыг боловсруулахдаа үндсэн дансны хуулгаар боловсруулсан зөрчил илэрч санхүүгийн тайланд залруулга хийлгэв.

Аудитаар дараах 2887,9 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа зөрчилд төлбөрийн акт тогтоолоо. Үүнд:

1. Дотуур байрны Хүүхдийн хоолны зардлын төсвийн хэмнэлтээр худалдан авалт хийж тайлант хугацааны эцэст 2446,7 мянган төгрөгийн хүнсний материал нөөцөлж үлдэгдлээр тайлагнасан байна.
   Энэ нь Төсвийн тухай хуулийн Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Засгийн газрын 2012 оны 106 дугаар тогтоолын 4-т "Нэг хүүхдэд ногдох дундаж нормативаар санхүүжүүлэх зардлын гүйцэтгэлийг хүүхэд өдрөөр хянаж зөрүүг тооцож байх" гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.
2. Нийгмийн даатгалын шимтгэлийн авлагын тооцоог тухай бүр нь хийгээгүйгээс өмнөх оны авлагыг бүрэн барагдуулаагүй тайлант онд 441,2 мянган төгрөгийн авлага үүссэн байна.
   Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4 дэх заалтыг зөрчсөн байна.

<u>Шийдвэрлэсэн нь:</u> Төлбөрийн акт тогтоов.

Аудитаар биет бус хөрөнгийн ашиглалттай холбоотой зөрчилд зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

## 2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Байхгүй

## 2.13. Шилэн дансны мэдээлэл

Галуут сумын Ерөнхий боловсролын сургуулийн Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг байршуулсан байдал дараах байдалтай байна. Үүнд:

2019 оны мэдээлэл оруулсан байдал дараах байдалтай байна.

| д/д | Хугацаа | Төрөл | Удаа | Хугацаанд оруулсан | Хугацаа хоцроосон | Хугацаа болоогүй |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | Бүтэн жил | 11 | 11 | 1 | 5 | 5 |
| 2 | Хагас жил | 4 | 4 | 4 | | |
| 3 | Улирал бүр | 1 | 4 | 2 | 2 | |
| 4 | Сар бүр | 3 | 36 | 34 | 11 | |
| 5 | Тухай бүр | 8 | 96 | 78 | 27 | |
| | Нийт | 27 | 151 | 119 | 45 | 5 |

Улирал бүр мэдээлдэг төсвийн гүйцэтгэлийн мэдээний 3 дугаар улирлын мэдээ, тухай бүр мэдээлэх "Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт өөрчлөлт"-ийн 8 дугаар сарын мэдээ, нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах заасан мэдэгдлийн 8 дугаар сарын мэдээ зэрэг эдгээр 3 мэдээг хоцроосон байна. Мөн тухай бүр мэдээлэх таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр хаяг-ийн 1-9 дүгээр сарын мэдээ мэдээллийг 2,3,4,8 дугаар мэдээг 10 сард нэмэлт зааварчилгаа өгсний улмаа дахин засварлан өөрчлөлт оруулсны улмаас хоцроосон байна.

## 2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж байхгүй

## 2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Галуут сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

"Зөрчилгүй" дүгнэлт

Галуут сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4.1.3 дахь заалт, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

## 1.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

**СТ-1А**

### САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 56,492,329.94 | 71,179,383.00 |
| 33 | АВЛАГА | 575,630.00 | 441,272.00 |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 575,630.00 | 441,272.00 |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 55,916,699.94 | 70,738,111.00 |
| 354 | Хангамжийн материал | 55,916,699.94 | 70,738,111.00 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 959,420.00 | 2,529,180.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 54,194,329.94 | 60,554,581.00 |
| 35450 | Барилгын засварын материал | 245,000.00 | 5,207,650.00 |
| 35460 | Хүнсний материал | 517,950.00 | 2,446,700.00 |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 1,538,351,388.98 | 1,545,407,727.54 |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 1,538,351,388.98 | 1,545,407,727.54 |
| 392 | Биет хөрөнгө | 1,500,227,643.26 | 1,507,293,256.82 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 1,367,163,240.00 | 1,367,163,240.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | 00.00 | -11,606,590.12 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 00.00 | 28,000,000.00 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 150,629,073.27 | 142,232,721.27 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -97,804,511.20 | -94,958,322.50 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 144,568,985.22 | 146,091,352.22 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -75,473,602.23 | -78,180,362.25 |
| 39217 | Ном | 11,144,458.20 | 8,551,218.20 |
| 393 | Биет бус хөрөнгө | 38,123,745.72 | 38,114,470.72 |
| 39301 | Програм хангамж | 352,600.00 | 352,600.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -228,854.28 | -238,129.28 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 38,000,000.00 | 38,000,000.00 |
| 3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II | 1,594,843,718.92 | 1,616,587,110.54 |
| 4 | НИЙТ ӨР ТӨЛБӨР | 464,522.00 | 150,000.00 |
| 41 | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | 464,522.00 | 150,000.00 |
| 413 | Өглөг | 464,522.00 | 150,000.00 |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | 464,522.00 | 150,000.00 |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 1,594,379,196.92 | 1,616,437,110.54 |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 1,594,379,196.92 | 1,616,437,110.54 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 1,308,640,649.12 | 1,308,640,649.12 |
| 51101 | Өмч: - төрийн | 1,308,640,649.12 | 1,308,640,649.12 |

| | | | |
|---|---|---|---|
| 512 | Хуримтлагдсан үр дүн | -251,615,623.00 | -229,557,709.38 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | -251,615,623.00 | -251,615,623.00 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 22,057,913.62 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 537,354,170.80 | 537,354,170.80 |
| 6 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V | 1,594,843,718.92 | 1,616,587,110.54 |

### 4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

**СТ-2А**

## САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 772,705,171.00 | 927,651,997.00 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 52,255,280.00 | 30,129,297.00 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 52,255,280.00 | 30,129,297.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 52,255,280.00 | 30,129,297.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 540,000.00 | 1,129,297.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 51,715,280.00 | 29,000,000.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 10,225,691.00 | 165,893,100.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 710,224,200.00 | 731,629,600.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 3,119,000.00 | 26,000,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 3,119,000.00 | 26,000,000.00 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 00.00 | 139,893,100.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 00.00 | 139,893,100.00 |
| 2 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 780,992,643.83 | 899,564,393.59 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 780,992,643.83 | 899,564,393.59 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 736,157,915.83 | 861,906,694.59 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 432,201,011.00 | 531,459,026.00 |
| 210101 | Үндсэн цалин | 397,891,068.00 | 484,288,439.00 |
| 210104 | Урамшуулал | 34,309,943.00 | 47,170,587.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 51,696,760.00 | 67,423,604.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 51,696,760.00 | 67,423,604.00 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 133,898,551.00 | 134,158,844.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 4,392,551.00 | 5,411,044.00 |
| 210302 | Түлш, халаалт | 128,690,400.00 | 127,691,800.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 815,600.00 | 1,056,000.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 5,362,445.00 | 21,858,773.94 |
| 210401 | Бичиг хэрэг | 565,480.00 | 1,559,640.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 3,148,520.00 | 2,714,800.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 399,445.00 | 1,520,185.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 92,500.00 | 29,400.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 00.00 | 73,400.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,007,600.00 | 1,389,400.00 |
| 210407 | Аж ахуйн материал худалдан авах зардал | 148,900.00 | 14,571,948.94 |
| 2105 | Нормативт зардал | 38,786,559.00 | 31,872,810.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 376,500.00 | 418,900.00 |
| 210502 | Хоол, хүнс | 38,368,059.00 | 31,061,210.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 42,000.00 | 392,700.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 5,683,000.00 | 17,434,550.00 |
| 210604 | Урсгал засвар | 5,683,000.00 | 17,434,550.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 286,000.00 | 1,658,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 286,000.00 | 1,658,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 400,000.00 | 7,615,800.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 400,000.00 | 7,215,800.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 00.00 | 400,000.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 67,843,589.83 | 48,425,286.65 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 1,163,463.00 | 3,748,015.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 4,154,600.00 | 1,522,500.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 62,525,526.83 | 43,154,771.65 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 44,834,728.00 | 37,657,699.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 44,455,680.00 | 35,478,562.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 17,661,589.00 | 20,309,580.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 200,000.00 | 15,168,982.00 |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 379,048.00 | 1,407,934.00 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 379,048.00 | 1,407,934.00 |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 00.00 | 1,203.00 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 00.00 | 1,203.00 |
| 2135 | Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг | 00.00 | 770,000.00 |
| 213501 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 00.00 | 770,000.00 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2) | -8,287,472.83 | 28,087,603.41 |
| 225 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН | 270,927,730.09 | 6,029,689.79 |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 242,161,170.29 | 6,029,689.79 |
| 4 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225) | - 270,927,730.09 | -6,029,689.79 |
| 5 | НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4) | - 279,215,202.92 | 22,057,913.62 |

**4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан**

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

**СТ-2А**

**МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

/Төгрөгөөр/

| Галуут сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит | | | |
|---|---|---|---|
| **Дансны код** | **Үзүүлэлт** | **Өмнөх оны гүйцэтгэл** | **Тайлант оны гүйцэтгэл** |
| | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | | |
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1) | 720,989,891.00 | 898,651,997.00 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 540,000.00 | 1,129,297.00 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 540,000.00 | 1,129,297.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 540,000.00 | 1,129,297.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 540,000.00 | 1,129,297.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 720,449,891.00 | 897,522,700.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 710,224,200.00 | 731,629,600.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 3,119,000.00 | 26,000,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 3,119,000.00 | 26,000,000.00 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 00.00 | 139,893,100.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 00.00 | 139,893,100.00 |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2) | 720,989,891.00 | 898,651,997.00 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 720,989,891.00 | 898,651,997.00 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 673,136,819.00 | 861,196,838.00 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 431,114,409.00 | 527,608,495.00 |
| 210101 | Үндсэн цалин | 346,848,853.00 | 427,353,217.00 |
| 210102 | Нэмэгдэл | 55,812,900.00 | 53,800,500.00 |
| 210104 | Урамшуулал | 28,452,656.00 | 46,454,778.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 52,405,337.00 | 71,454,299.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 35,132,713.00 | 50,183,162.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 4,317,944.00 | 5,318,600.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,454,550.00 | 4,254,737.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,020,059.00 | 1,060,300.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 8,480,071.00 | 10,637,500.00 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 133,391,371.00 | 134,158,844.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 4,645,051.00 | 5,411,044.00 |
| 210302 | Түлш, халаалт | 127,690,400.00 | 127,691,800.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,055,920.00 | 1,056,000.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 5,188,445.00 | 10,324,585.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 663,900.00 | 1,406,900.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 2,908,200.00 | 2,608,200.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 399,445.00 | 1,520,185.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 465,500.00 | 3,047,100.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 00.00 | 180,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 751,400.00 | 1,562,200.00 |
| 2105 | Нормативт зардал | 35,727,500.00 | 34,493,100.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 182,200.00 | 331,800.00 |
| 210502 | Хоол, хүнс | 35,082,950.00 | 32,899,600.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 462,350.00 | 1,261,700.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 6,739,000.00 | 40,304,300.00 |
| 210602 | Тавилга | 3,900,000.00 | 15,781,100.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210604 | Урсгал засвар | 2,839,000.00 | 24,523,200.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 286,000.00 | 1,658,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 286,000.00 | 1,658,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 284,300.00 | 27,913,300.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 284,300.00 | 27,513,300.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 00.00 | 400,000.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 8,000,457.00 | 13,281,915.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 2,308,757.00 | 8,333,415.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 5,691,700.00 | 4,948,500.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 47,853,072.00 | 37,455,159.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 47,474,024.00 | 36,046,022.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 20,679,933.00 | 20,487,040.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 200,000.00 | 15,558,982.00 |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 379,048.00 | 1,407,934.00 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 379,048.00 | 1,407,934.00 |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 00.00 | 1,203.00 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 00.00 | 1,203.00 |

### 4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

**СТ-4А**

**ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН**

/ төгрөгөөр /

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Бусад | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|---|
| C01 | 2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 1,270,640,649.12 | 335,342,731.00 | 27,599,579.83 | 00.00 | 1,633,582,959.95 |
| C03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 1,270,640,649.12 | 335,342,731.00 | 27,599,579.83 | 00.00 | 1,633,582,959.95 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | 38,000,000.00 | 00.00 | -279,215,202.92 | 00.00 | -241,215,202.92 |
| C08 | 2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 1,308,640,649.12 | 537,354,170.80 | -251,615,623.00 | 00.00 | 1,594,379,196.92 |
| D01 | 2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 1,308,640,649.12 | 537,354,170.80 | -251,615,623.00 | 00.00 | 1,594,379,196.92 |
| D03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 1,308,640,649.12 | 537,354,170.80 | -251,615,623.00 | 00.00 | 1,594,379,196.92 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 22,057,913.62 | 00.00 | 22,057,913.62 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| D09 | 2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 1,308,640,649.12 | 537,354,170.80 | -229,557,709.38 | 00.00 | 1,616,437,110.54 |

## 4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

ТГ

### ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Өмнөх оны | | Тайлант оны | |
|---|---|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| 1 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | | | |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 608,343,000.00 | 595,032,715.00 | 871,522,700.00 | 870,113,563.00 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 608,343,000.00 | 595,032,715.00 | 871,522,700.00 | 870,113,563.00 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 576,701,200.00 | 563,400,745.00 | 835,427,200.00 | 834,067,541.00 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 434,909,000.00 | 423,123,950.00 | 527,934,600.00 | 527,585,760.00 |
| 210101 | Үндсэн цалин | 333,724,700.00 | 329,855,925.00 | 424,862,500.00 | 427,330,482.00 |
| 210102 | Нэмэгдэл | 44,365,200.00 | 44,712,675.00 | 56,372,600.00 | 53,800,500.00 |
| 210104 | Урамшуулал | 36,990,300.00 | 30,016,250.00 | 46,699,500.00 | 46,454,778.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 48,033,900.00 | 46,532,569.00 | 71,482,400.00 | 71,454,299.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 48,033,900.00 | 46,532,569.00 | 50,184,000.00 | 50,183,162.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 00.00 | 00.00 | 5,324,600.00 | 5,318,600.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 00.00 | 00.00 | 4,259,700.00 | 4,254,737.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 00.00 | 00.00 | 1,064,900.00 | 1,060,300.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 00.00 | 00.00 | 10,649,200.00 | 10,637,500.00 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 42,223,000.00 | 42,222,905.00 | 133,393,100.00 | 133,392,547.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 4,645,100.00 | 4,645,100.00 | 4,645,100.00 | 4,644,747.00 |
| 210302 | Түлш, халаалт | 36,107,900.00 | 36,107,805.00 | 127,692,000.00 | 127,691,800.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,470,000.00 | 1,470,000.00 | 1,056,000.00 | 1,056,000.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 6,533,100.00 | 6,522,775.00 | 10,343,000.00 | 10,324,585.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,376,400.00 | 1,366,400.00 | 1,407,400.00 | 1,406,900.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 2,344,900.00 | 2,344,900.00 | 2,608,200.00 | 2,608,200.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,414,800.00 | 1,414,475.00 | 1,521,000.00 | 1,520,185.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 273,200.00 | 273,200.00 | 3,063,800.00 | 3,047,100.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 00.00 | 00.00 | 180,000.00 | 180,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,123,800.00 | 1,123,800.00 | 1,562,600.00 | 1,562,200.00 |
| 2105 | Нормативт зардал | 31,658,800.00 | 31,658,590.00 | 34,546,200.00 | 34,493,100.00 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 210502 | Хоол, хүнс | 30,918,100.00 | 30,917,990.00 | 32,814,600.00 | 32,899,600.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 461,700.00 | 461,700.00 | 1,216,700.00 | 1,261,700.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 1,371,700.00 | 1,371,700.00 | 40,305,000.00 | 40,304,300.00 |
| 210602 | Тавилга | 00.00 | 00.00 | 15,805,000.00 | 15,781,100.00 |
| 210604 | Урсгал засвар | 1,371,700.00 | 1,371,700.00 | 24,500,000.00 | 24,523,200.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 560,500.00 | 557,600.00 | 1,662,400.00 | 1,658,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 560,500.00 | 557,600.00 | 1,662,400.00 | 1,658,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 538,000.00 | 537,600.00 | 2,811,000.00 | 1,913,300.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 538,000.00 | 537,600.00 | 2,411,000.00 | 1,513,300.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 00.00 | 00.00 | 400,000.00 | 400,000.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 10873200.00 | 10873056.00 | 12949500.00 | 12941650.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 10,873,200.00 | 10,873,056.00 | 8,000,000.00 | 7,993,150.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 00.00 | 00.00 | 4,949,500.00 | 4,948,500.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 31641800.00 | 31631970.00 | 36095500.00 | 36046022.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 31,641,800.00 | 31,631,970.00 | 36,095,500.00 | 36,046,022.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 18,795,000.00 | 18,785,170.00 | 20,496,000.00 | 20,487,040.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 00.00 | 00.00 | 15,599,500.00 | 15,558,982.00 |
| | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 608,043,000.00 | 595,032,284.00 | 871,522,700.00 | 870,113,563.00 |
| 1310 | УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 608,043,000.00 | 595,032,284.00 | 731,629,600.00 | 730,221,666.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 608,043,000.00 | 595,032,284.00 | 731,629,600.00 | 730,221,666.00 |
| 1320 | ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 00.00 | 00.00 | 139,893,100.00 | 139,891,897.00 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 00.00 | 00.00 | 139,893,100.00 | 139,891,897.00 |
| 62 | АЖИЛЛАГСАДЫН ТОО | 00.00 | 00.00 | 54.00 | 54.00 |
| 620001 | Удирдах ажилтан | 00.00 | 00.00 | 04.00 | 04.00 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 00.00 | 00.00 | 31.00 | 31.00 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 00.00 | 00.00 | 19.00 | 19.00 |
| 630 | ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД | 204.00 | 202.00 | 168.00 | 166.00 |

### 4.6 Аудит хийгдсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

НТ-2

## НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Гүйцэтгэл | |
|---|---|---|---|---|
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | | |
| I | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | | 26000000 | |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | | 26000000 | |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | | 26000000 | |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | | 26000000 | |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | | 26000000 | |
| IV | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I) | | | |

АУДИТЫН ТАЙЛАНГ:

БЭЛТГЭСЭН:АУДИТОР БЯМБАА

АНХАН ШАТАНД ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР А.ЦЭЭНЯМ

ХОЁР ДАХЬ ШАТАНД ХЯНАСАН:

ДАРГА ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Б.МӨНХБАТ